



ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ


2020 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/111

Улаанбаатар хот

Маргаан шийдвэрлэх комиссын тогтоолыг
баталгаажуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Оюуны өмчийн газрын дэргэдэх маргаан шийдвэрлэх комиссын ажиллах журмын 5.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Кредит банк” ХХК-иас ирүүлсэн мэдүүлгийн 40-0024434 дугаартай “” дүрсэн барааны тэмдгийг бүртгэхээс татгалзсан шийдвэрийг хүчингүй болгуулах тухай гомдлын шаардлагыг хангаж шийдвэрлэсэн Оюуны өмчийн газрын дэргэдэх Маргаан шийдвэрлэх комиссын 2020 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 08 дугаар тогтоолыг баталгаажуулсугай.

2. Маргаан шийдвэрлэх комиссын тогтоолыг баталгаажуулсантай холбогдуулж хэрэгжилтийг хангаж ажиллахыг Маргаан шийдвэрлэх комисс /С.Ганзориг/-т даалгасугай.

ДАРГА

Ц.АЗБАЯР